

## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

### Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

### Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: javkhlan@khurdan.gov.mn цахим шуудан
- Холбоо барих утас: 260304, 88102031

## Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	Чанар хяналтын газар	Чанар хяналтын газрын дарга	1	Төрийн захиргааны удирдах	Эрхэлсэн түшмэл ТЗ-3	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	<a href="https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/06/Chanar-hyanaltiin-gazriin-dargiin-ATT.pdf">https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/06/Chanar-hyanaltiin-gazriin-dargiin-ATT.pdf</a>	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
2	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Захиргаа удирдлагын газар	Хуулийн ахлах мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-6	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	<a href="https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/06/Huuliin-ahlah-mergejiltanii-ATT.pdf">https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/06/Huuliin-ahlah-mergejiltanii-ATT.pdf</a>	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно;
3	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Захиргаа удирдлагын газар	Хүний нөөцийн мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	<a href="https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/06/Hunii-nuutsiin-mergejiltanii-ATT.pdf">https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/06/Hunii-nuutsiin-mergejiltanii-ATT.pdf</a>	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно;